



## Товч танилцуулга

ХҮД-ийн Нэгдсэн эмнэлэг нь 1980 оны 4-р сард Ажилчны Районы хүүхдийн нэгдсэн эмнэлэг нэртэйгээр анх байгуулагдан, хэвтэн эмчлэх 120 ортой, нэг зэликийн 300 хүүхдэд үйлчилэх хүчин чадалтай поликлиниктэйгээр үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

1991 оны 4-р сард ЭМСайдын А/39, Улаанбаатар хотын АДХГЭ-ны 83-р томооолоор нийслэлийн дүүргүүдэд эрүүл мэндийн зөвлөх төвүүд байгуулагдаж, амбулатори поликлиникийн үйлчилгээг шилжүүлснээр хүүхдийн сувчний чиглэлээр хэвтэн эмчлэх үйлчилгээтэй Хүүхдийн 4-р эмнэлэг болж сөрчлөгдсөн.

Тус эмнэлгийг Эрүүл мэндийн Сайд, Нийслэлийн Засаг даргын 2001 оны 4-р сарын 24-ны өдрийн 98/197 тоот хамтарсан тушаал, захирамжаар

Дүүргийн нэгдсэн эмнэлэг болон сөрчлөн зохион байгуулж, эмнэлгийн тусlamж үйлчилгээний хурээ, нертерлийг нэмэгдүүлсэн юм. Одоо тус эмнэлэг нь үйлчилэх хурээний хүн амд хүүхэд, дотор-мэдрэл, мэс засал, уламжлалт эмчилгээ, онцшлогооны чиглэлээр эмнэлгийн хоёрдогч шаталалын тусlamжийг узүүлдэг. Нийтдээ 80 гаруй эмч, эмнэлгийн ажилтан ажиллаж байгаагаас их эмч 19, сувилагч эмнэлгийн тусгай мэргэжилтэн 30 гаруй ажиллаж байна. Тус эмнэлэг нь хэвтүүлэн эмчлэх 115 ортой ажиллаж, жилдээ 40000 гаруй хүн эмчлэн, 41000 ор хоног ашигладаг. Манай эмнэлгийн хамт олон үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээ шаардлагыг хангаж чадахуйц эмнэлгийн тусlamж үйлчилгээг эслэг шуурхай, чанарын сайдер түвшинд узүүлэх зорилт тавин чармайн ажиллаж байна.

# ҮЙЛЧЛУУЛЭГ

танд итгэлийн илчийг  
таны итгэлийн галыг  
бид өгч,  
бид бадраана.

## ДОТОР -МЭДРЭЛИЙН ТАСАГ

Дотрын тасаг нь анх 1993 онд 50 ортойгоор байгуулагдсан. Дүүргийн 4-8-р хорооны насанд хүрэгчдэд дотор, мэдрэлийн өвчний чиглэлээр эмнэлгийн тусlamжийг үзүүлдэг. Тус тасаг нь нөхцлийн нэмэгдэлтэй тохилог палат, нөхөн сэргээх, эрчимт эмчилгээ болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх төрөлжсөн палатуудтай. Жилдээ дундачаар 2200 хүн хэвтүүлэн эмчилж 19800 ор хоног ашигладаг. Одоо тус тасагт нь 18 эмч ажилтантай. Үүнээс их эмч 4 сувилагч 8 ажиллаж байна.



## МЭС ЗАСЛЫН ТАСАГ

Мэс заслын тасаг нь Нийслэлийн ЭМГазрын шийдвэрээр 2002 оны 11-р сард 10 ортой, 6 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.

Нийслэлийн хэмжээнд анх удаа дүүргийн эмнэлэгт мэс заслын тусlamжийг үзүүлэх болсноор үйлчлүүлэгчдийн чирэгдлийг багасгаж эмнэлгийн тусlamжийн үйлчилгээнд шинэ дэвшил гаргасан юм. Тус тасаг нь жилдээ дундачаар 135 хүнд мэс заслын эмчилгээ хийж, 1200 ор хоног ашигладаг.

## ХҮҮХДИЙН ТАСАГ

Хүүхдийн тасаг нь 1980 оны 4-р сард 120 ортойгоор анх байгуулагдсан. Одоо тус тасаг нь 50 ортой, 17 эмч ажилтантай ажиллаж байна.

Эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулахуйн тусlamжийг өргөтгөн зохион байгуулж, эрчимт эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглосон. Тус тасаг нь төрөлжсөн сувилааны болон тоглоомын өрөөтэй, жилдээ дундачаар 1700 хүүхэд хэвтүүлэн эмчилж 15000 ор хоног ашигладаг.



## АЖ АХҮЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСАГ

Эмнэлгийн аж ахуй үйлчилгээний тасаг нь эмнэлгийн тусламж үйлчилгээг хэвийн явуулах нөхцлийг хангаж өгдөг.

Тус тасаг нь 19 ажилтантай. Нэг ээлжиндээ 150 хүнд үйлчлэх хүчин чадалтай эмнэлгийн гал тогоо өвчтөн үйлчлүүлэгч нарт эмчилгээний болон ердийн хоолоор үйлчилдэг. Эмнэлгийг цэвэр усаар хангах гүний худаг, халаалтын болон уурын тогоо бүхий уурын зуух, дезкамер, нэгдсэн угаалга, харуул хамгаалалтын хэсэгтэйгээр ажилладаг.

## НЭГДСЭН ЛАБОРАТОРИ

Клиникийн болон биохимийн лабораториид 1 их эмч, 3 лаборант ажиллаж цус, шээсний болон биохимийн бүх төрлийн шинжилгээнүүдийг хийдэг.

Шинжилгээнүүдээ орчин үеийн анализаториар хийж гүйцэтгэдэг бөгөөд клиникийн лабораториид цусны болон шээсний өрөнхий шинжилгээ, нугасны ус, плеврийн шингэн, хэвлэлийн шингэний шинжилгээг, биохимийн лабораториид элэг бөөрний, зүрхний үйл ажиллагааны төрөлжсөн шинжилгээнүүдийг хийдэг.



## ЭМИЙН БУС НӨХӨН СЭРГЭЭХ ЭМЧИЛГЭЭ

Хэвтэн эмчилүүлэгсдэд нөхөн сэргээх болон уламжлалт эмчилгээний чиглэлээр зүү төөнүүр, бүх төрлийн бария засал, хэт ягаан туяаны шарлага, цахилгаан эмчилгээ, хөдөлгөөн-тренежёр эмчилгээ зэрэг үйлчилгээг үзүүлдэг. Жилдээ дундачаар 3300 хүнд сэргээх эмчилгээг хийдэг.



## ЭМИЙН САН

Тус эмнэлэгт 2-р зэрэглэлийн эмийн сан ажиллаж 200 гаруй нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслээр хангальт хийдэг ба 12 нэр төрлийн тарилгын ариун шингэн бэлтгэж, 7 нэр төрлийн усан эм бэлтгэж эмчилгээнд хэрэглэж байна.



## ҮЙЛ ОНОШИЙН ШИНЖИЛГЭЭ

Рентген кабинетэд гэрэлд харах, зураг авах, тодотгоч бодистой зураг авах зэрэг шинжилгээнүүдийг хийдэг бөгөөд ЭХО болон өндөр хүчин чадалтай зүрхний бичлэгийн аппаратаар оношлогоог шинээр хийж байна.

Зөөврийн болон суурин ЭХО аппаратаар бүрэн тоноглогдсон.



## ЭРҮҮЛ МЭНДИЙН СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА



Нэгдсэн эмнэлгийн хамт олон эмнэлгийн үндсэн тусlamж үйлчилгээнээс гадна нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх, эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг амьдралд хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж байна. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор ЭМС Сурталчилгааны тэнхимийг шинээр байгуулж, үйл ажиллагааг нь тогтмолжуулсан ба сургууль хүүхдийн байгууллагуудад эрүүл мэндийг сургалтыг графикаар явуулж байна.

## ХҮЛЭЭН АВАХ БА ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ХЭСЭГ

Тус эмнэлгийн хүлээн авах хэсэг нь өвчтөн хүлээн авах өрөө, яаралтай тусlamж үзүүлэх хэсэг, тусгаарлах өрөөнүүдтэй. Ээлжийн сувилагч нар ажиллаж эмнэлгийн яаралтай тусlamжийг үзүүлдэг.

